

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны
98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт

БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХОРШОО, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Б.БААСАНСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
ЗОРИЛТ НЭГ. “АЙМГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ”							
1.	1.1.Аймгийн Засаг даргын ажиллагааны хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Эрдэнэт хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг гүйцэтгэх, тайлагнах	-Хэрэгжилтийн хувь	90.0 хувь	Төлөвлөгөөний хэрэгжилт 60-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна.	Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах зорилтын хүрээнд 7, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагыг хангах зорилтын хүрээнд 8, инновацийг олон нийтэд сурталчлах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд 1 арга хэмжээ, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд шинжлэх ухаан технологи, хүнс, хөдөө аж ахуй, стандарт, малын эрүүл мэнд чиглэлээр 7 зорилтын хүрээнд 15 арга хэмжээ, Орхон аймаг, Эрдэнэт хотын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд салбарын чиглэлээр 34 арга хэмжээ тусган ажиллаж байна. Дээрх бодлогын баримт бичиг тусгасан ажлуудын хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах, орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор ХХААХҮЯ, ЖДҮГ, аймгийн ЗДТГ-тай “Ерөнхий нөхцөл тохиролцох, хамтран ажиллах гурван талт гэрээ” байгуулж, орон нутгийн төсвөөс 300,000,000 /Гурван зуун сая/ төгрөгийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, 16.6-т заасны дагуу тухайн орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, хөнгөлөлттэй зээл олгох	2025-01-01 2025-06-05	90

					зориулалтаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн дансанд байршуулахаар гэрээ байгуулсан. “Өрхийн тариалалтыг дэмжих” хөтөлбөрийг үргэлжлүүлэх хэрэгжүүлэхээр 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулж, хөтөлбөрт 500 өрх хамруулан төмс, хүнсний ногооны үр, хүлэмж олгохоор төлөвлөн ажиллаж байна. Ахуйн үйлчилгээний салбарын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2025 оны А-452 захирамжаар батлуулан орон нутгийн төсвөөс 8.0 сая төгрөг зарцуулан ажиллаж байна. Аймгийн хүн амын 2025 оны хаврын улирлын махны нийлүүлэлт, хангамж, үнийн түвшинг тогтвортой хадгалах зорилгоор гарал үүсэл нь баталгаажсан, үйлдвэрийн аргаар бэлтгэсэн, эрүүл ахуй, ариун цэвэр, стандартын шаардлага хангасан үхэр, хонь, ямааны махыг хүн амын хүнсний хэрэгцээнд зориулан гаргахаар аймгийн ЗДТГ-аас Эрдмийт ХХК-тай “Мах бэлтгэх, хадгалах, борлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урамшуулал олгох” гэрээ байгуулсан. Тус компани 2-3 кг-аар ангилж савласан махыг 2025 оны 03 сарын 15-ны өдрөөс эхлэн 06 сарын 05-ны өдрийг дуустал хугацаанд 30-аас доошгүй цэгээр худалдан борлуулж үхрийн мах 1 кг нь 12300, хонь 10300, ямаа 8300 төгрөгөөр худалдаалах ажлыг зохион байгуулсан. 06 сарын 05-ны байдлаар 6.7 тн махны үлдэгдэлтэй бөгөөд борлуулалт 96.7 хувь, үхэр 4.6 тн, хонь 2.1 тн үлдэгдэлтэй, ямааны мах дууссан байна. “Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд хоршооны салбарт 2025 оны хийгдэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан ажиллаж байна. “Эрдэнэтэд үйлдвэрлэв” төвийн барилгын зураг төсвийг боловсруулж, зургийн дагуу барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Мал, амьтны гоц халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж өвөлжөө, хаваржааны ойр орчмын зудад хорогдсон малын сэг, зэм устгах, урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулж байна.		
2.	1.2.Аймгийн Засаг Зөвлөлийн даргын	Холбогдох асуудлуудыг 100	100.0 хувь	Холбогдох асуудлуудыг	Аймгийн ИТХ-ын 2025 онд Хурлын зөвлөл, Ээлжит, Ээлжит бус хуралдаануудаар	2025-01-01	100

	хурал, аймгийн ИТХ-ын Зөвлөлийн Хуралдаанд холбогдох асуудлуудыг хэлэлцүүлэх	хувь хэлэлцүүлсэн байна.		хугацаанд нь хэлэлцүүлсэн байна.	хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх Орхон аймгийн 2022-2027 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2 сард, Орхон аймгийн хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг 4 сард батлуулах, хэрэгжилтийн явцын тайланг 8 сард танилцуулах, Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилтийг 10 сард тайлагнахаар тусгасан. Төлөвлөгөөний дагуу "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх Орхон аймгийн 2022-2027 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2 дугаар сард тайлагнасан. Тус төлөвлөгөө 87.9 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн ИТХ-ын Зөвлөлийн Хуралдаанаар хэлэлцүүлж аймгийн ИТХ-ын Хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахаар ажиллаж байна. Тус төлөвлөгөөнд мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах талаар 11, мал эмнэлгийн ажил үйлчилгээний чиглэлээр 4, газар тариалангийн бэлтгэл хангах талаар 10, хүнсний чиглэлээр 1 арга хэмжээ тусгагдсан.	2025-06-05	
3.	1.3.ХХААХҮСайд, Орхон аймгийн Засаг даргын нарын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах, тайлагнах	Гэрээний хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувь ханган ажилласан.	Гэрээний хэрэгжилтийг 97.3 хувь ханган ажилласан.	-	ХХААХҮСайд, Орхон аймгийн Засаг даргын нарын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээнд мал аж ахуй, газар тариалан, хөнгөн үйлдвэр, хүнсний үйлдвэр, жижиг, дунд үйлдвэр, бусад чиглэлээр тусгагдсан нийт 36 арга хэмжээний хэрэгжилтийг ханган, гэрээнд заасан хугацаа буюу 7 дугаар сард багтаан тайлагнахаар ажиллаж байна. "Атар-IV" тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг улсын хэмжээнд эрчимжүүлэн хэрэгжүүлэхээр Засгийн газрын 47-р тогтоол батлагдан гарсан. Уг аяны хүрээнд Засгийн газрын хүүгийн дэмжлэгтэй, хөнгөлөлттэй зээлд хамрагдах эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 19, туслах аж ахуй 2, тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр 1 иргэний мэдээллийг хүргүүлсэн. Малчид тариаланчдын зөвлөгөөн 2025-04-25нд Жаргалант суманд зохион байгуулагдаж 200 хүнийг хамруулсан. Монгол улсын их хурал, Засгийн газар, орон нутгийн бодлого, шийдвэрүүдийг танилцуулж санал хүсэлт авч ажилласан. "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд 40 хоршоо шинээр байгуулагдаж, 5.7	2025-01-01 2025-06-05	90

					тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсанаар 43 ажлын байр шинээр нэмэгдсэн. Малчдын нэгдсэн эрх ашигт тулгуурлан шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд шинээр 66 хоршоо байгуулагдсаны 37 малчны хоршоо байгуулагдсан. Хоршоодын үйл ажиллагааг дэмжиж 10.97 га газрыг 3 хоршоонд олгосон. Сүү” хөтөлбөрийн хүрээнд: “Өдөр бүр нэг аяга сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлж 1-5-р ангийн 11300 хүүхдэд 3 өдөр үдийн хоолон дээр нэмэлтээр 150-200гр сүү, сүүн бүтээгдэхүүн өгч байна. 6-р ангийн 2350 хүүхдэд “Сүү” ХХК-тай гэрээлж өдөрт 1000 төгрөгийн өртөг бүхий 180-200 гр сүү өгсөн байна.		
4.	1.4."Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх Орхон аймгийн 2022-2027 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувь ханган ажилласан байна.	85.7 хувь	Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг Орхон аймагт 2022-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12/02 дугаар тогтоолоор батлуулж, 23 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ онд тус төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулалтын 24 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган ажиллаж байна. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний Орхон аймгийн 2022-2027 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2025 оны аймгийн төсөвт 35.0 сая төгрөг батлагдсан. “Атар-4” тариалангийн тогтвортой аяны хүрээнд хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлээс газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 1 аж ахуйн нэгж, 2 иргэн эргэлтийн хөрөнгийн 375.0 сая төгрөг, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 2 иргэн 100.0 сая төгрөг, нийт 1 аж ахуйн нэгж, 4 иргэн 475.0 сая төгрөгийн зээл олгогдож, ХХААГ зээлдэгчидтэй хяналтын гэрээ байгуулсан. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд стандарт, техникийн зохицуулалтыг мөрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, НАССР болон ISO:22000 стандартыг үйлдвэрүүдэд нэвтрүүлэх замаар иргэдийн хүнсний аюулгүй байдлыг хангах, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахаар орон нутгийн төсвөөс 25.0	2025-01-01 2025-06-05	90

					сая төгрөгийн санхүүжилт батлуулан ажиллаж байна. Аймгийн жишсэн дундаж нийт хүн амын 2025 оны хаврын махны хэрэгцээг 90 хоногоор тооцоход 926.8 тонн малын мах хэрэгцээтэй бөгөөд үүний 21.5 хувь буюу 200 тонн махны нөөц бүрдүүлэхээр төлөвлөсөн. Нөөцөд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах нь MNS 2456:2009, MNS 2457:2009 стандартын шаардлага хангасан байх ба махны нийт жингийн 55 хувь буюу 110 тн үхэр, 40 хувь буюу 80 тн хонь, 5 хувь буюу 10 тн ямааны мах байх бөгөөд ангилан савласан байдлаар худалдаанд нийлүүлэх сонгон шалгаруулалтад Эрдмийт ХХК шалгарч үхрийн мах 110 тонн, хонины мах 80 тонн, ямааны мах 10 тн, нийт 200 тонн махыг ангилж, савласан байдлаар нийлүүлж байна. Тус ажилд орон нутгийн төсвөөс 400.0 сая төгрөг зарцуулсан.		
5.	1.5."Малын эрүүл мэнд"-ийн хамгаалах чиглэлээр төлөвлөгдсөн ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллах	Холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	96.8 хувь	Ажлын хэрэгжилт 60 хувь	Мал сүргийг 2025 онд халдварт өвчнөөс эмчлэн урьдчилан сэргийлэх арга хэмжээний дархлаажуулалтын төлөвлөгөө, шимэгчтэх өвчнөөс сэргийлэх болон ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээний төлөвлөгөө, адууны тандалт шинжилгээ хийх төлөвлөгөөг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан, орон нутгийн төсвийн 100.8 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэн ажиллаж байна. Мал, амьтныг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулахад орон нутгийн төсвөөс гарахаас урьдчилан сэргийлж өвөлжөө, хаваржааны ойр орчмын зудад хорогдсон малын сэг, зэмийг устгах, урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийн арга хэмжээг цаг хугацаанд нь зохион байгуулан ажиллаж байна.	2025-01-01 2025-06-05	100
6.	1.6.Холбогдох ажлын хэсэг байгуулах, ажлын хэсэгт ажиллах	Ажлын хэсэгт орж ажилласан байна.	6 ажлын хэсэгт ажилласан.	Холбогдох ажлын хэсэгт орж ажилласан байна.	Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэх ажлын хэсэг, хүн амын хаврын хэрэгцээнд бэлтгэн нийлүүлэх аж ахуйн нэгжийн худалдаанд нийлүүлж буй маханд хяналт тавих, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд тусгай зориулалтын сангаас зээл олгох ажлын хэсэг, хаврын тариалалтыг технологийн хугацаанд чанартай гүйцэтгэх ажлыг хүлээн авах ажлын хэсэг, "Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо" нэвтрүүлэх ажлыг төр болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах, Хүлэг хүнсний захтай холбогдох	2025-01-01 2025-06-05	100

					асуудлыг шийдвэрлэх зэрэг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна.		
7.	1.7.Хүн амын хаврын хэрэгцээнд нөөцийн мах бэлтгэн борлуулах аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, тайлагнах	Хүн амын хаврын хэрэгцээнд нөөцийн мах бэлтгэн борлуулах, хяналт тавих ажлыг зохион байгуулсан байна.	Гэрээ байгуулан нөөцийн махыг иргэдэд хүргэн ажилласан.	Холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	Аймгийн жишсэн дундаж нийт хүн амын 2025 оны хаврын махны хэрэгцээг 90 хоногоор тооцоход 926.8 тонн малын мах хэрэгцээтэй бөгөөд үүний 21.5 хувь буюу 200 тонн махны нөөц бүрдүүлэхээр төлөвлөсөн. Нөөцөд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах нь MNS 2456:2009, MNS 2457:2009 стандартын шаардлага хангасан байх ба махны нийт жингийн 55 хувь буюу 110 тн үхэр, 40 хувь буюу 80 тн хонь, 5 хувь буюу 10 тн ямааны мах байх бөгөөд ангилан савласан байдлаар худалдаанд нийлүүлэх сонгон шалгаруулалтад Эрдмийг ХХК шалгарч “Мах бэлтгэх, хадгалах, борлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урамшуулал олгох” гэрээ байгуулсан. Нөөцийн махыг 2025 оны 03 сарын 15-ны өдрөөс эхлэн 06 сарын 05-ны өдрийг дуустал хугацаанд 30-аас доошгүй цэгээр худалдан борлуулж үхрийн мах 1 кг нь 12300, хонь 10300, ямаа 8300 төгрөгөөр худалдаалах ажлыг зохион байгуулсан. 06 сарын 05-ны байдлаар 6.7 тн махны үлдэгдэлтэй бөгөөд борлуулалт 96.7 хувь, үхэр 4.6 тн, хонь 2.1 тн үлдэгдэлтэй, ямааны мах дууссан байна.		100
8.	1.8.Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	-Хамтран ажилласан байгууллагын тоо	Тогоочдын холбоо ГҮТББ, Оёдолчдын холбоо, Эрдэнэт хот орчмын фермерүүдийн холбоо, Хүнсчдийн холбоо болон Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран ажилласан.	Хамтран ажилласан байна.	Салбарын чиглэлээр холбогдох төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж байна. Тайлант хугацаанд Тогоочдын холбоо ГҮТББ-тай хамтран Монгол үндэсний болон орон нутгийн онцлогтой уламжлалт хоол, идээ ундааны технологийг түгээн дэлгэрүүлэх, салбарын ажилтан, ажиллагсдын чадамж, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол үндэсний хоол, идээ ундааны “Аймгийн аварга тогооч” шалгаруулах уралдааныг зохион байгуулсан. Иргэний нийгмийн байгууллага болон төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх ажлын жагсаалтад туссан хүнсний худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааг стандарт шаардлага хангуулах, хяналт тавих ажлын хүрээнд сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаад байна.	2025-01-01 2025-06-05	90
9.	1.9.Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих ажил зохион байгуулах	Оролцогчдын тоо	2 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан.	Холбогдох чиглэлээр хамтран ажилласан байна.	ХХААХҮЯ, ЖДҮГ, аймгийн ЗДТГ-тай “Ерөнхий нөхцөл тохиролцох, хамтран ажиллах гурван талт гэрээ” байгуулж, орон нутгийн төсвөөс 300,000,000 /Гурван зуун сая/ төгрөгийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, 16.6-т заасны дагуу тухайн	2025-01-01 2025-06-05	90

					орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, хөнгөлөлттэй зээл олгох зориулалтаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн дансанд байршуулахаар гэрээ байгуулж санхүүжилтийг шилжүүлсэн. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгохоор материал хүлээн авч 3 шатны судалгаа хийгдэж 1.7 тэрбум төгрөгийн 12 төсөл нарийвчилсан судалгаанд хамрагдсан. 70-аас дээш оноо авсан төсөл нь 6 дугаар сард төсөл сонгон шалгаруулах дэд хорооны хурлаар хэлэлцэгдэж, шаардлага хангасан төсөлд санхүүжилтийн эрх олгохоор ажиллаж байна. Аймгийн ЗДТГ, ХААН, Капитрон банкт хамтран ажиллах гэрээний дагуу зээл хүссэн иргэн, аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн дэмжигдсэн төслүүдийг банкуудад уламжилсан. Тайлант хугацаанд сүүний чиглэлийн үнээ худалдан авах, өндөг үйлдвэрлэл, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх, махны чиглэлийн үхэр бордох газар байгуулах зэрэг төслүүдийг дэмжсэн.		
10.	1.10.Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах чиглэлээр ажиллах	90-ээс доошгүй хувиар хангасан байна.	99.6 хувь	Холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн ИТХ-ын Зөвлөлийн Хуралдаанаар хэлэлцүүлж аймгийн ИТХ-ын Хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахаар ажиллаж байна. Тус төлөвлөгөөнд мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах талаар 11, мал эмнэлгийн ажил үйлчилгээний чиглэлээр 4, газар тариалангийн бэлтгэл хангах талаар 10, хүнсний чиглэлээр 1 арга хэмжээ тусгагдсан.	2025-01-01 2025-06-05	90
11.	1.11.Өрхийн үйлдвэрлэл болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлээр холбогдох газруудтай хамтран ажиллах	-Дэмжин ажилласан өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо	Дэмжин ажилласан.	Холбогдох арга хэмжээг авч дэмжин ажилласан байна.	Аймгийн ЗДТГ, ХААН, Капитрон банкт хамтран ажиллах гэрээний дагуу зээл хүссэн иргэн, аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн дэмжигдсэн төслүүдийг банкуудад уламжилсан. Тайлант хугацаанд сүүний чиглэлийн үнээ худалдан авах, өндөг үйлдвэрлэл, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх, махны чиглэлийн үхэр бордох газар байгуулах зэрэг төслүүдийг дэмжсэн.	2025-01-01 2025-06-05	90

12.	1.12.Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээл хүссэн өргөдөл, материалыг хүлээн авах, арилжааны банкуудад уламжлах	-Хүлээн авсан төслийн тоо -Дэмжсэн төслийн тоо	Аймгийн ЖДҮ сангаас 5 зээл олгогдсон.	Зээл хүссэн өргөдлийг хүлээн авч ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж холбогдох газарт хүргүүлсэн байна.	"Орхон аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох журам", "Хөнгөлөлттэй зээл олгох шийдвэр гаргах ажлын хэсэг"-ийн аймгийн Засаг даргын 2024 оны А/145 дугаар захирамжаар батлуулсан. Жижиг, дунд болон өрхийн бичил үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ХААН, Капитрон, Төрийн банктai байгуулсан гэрээний хугацаа дууссантай холбогдуулан гэрээ сунгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр гэрээний төсөл, журмын хамт хүргүүлснээр ХААН, Капитрон банкууд гэрээг 5 жилийн хугацаатайгаар сунгасан. Төрийн банктai байгуулсан гэрээг банкны зүгээс сунгах боломжгүй болсон тул тус банк дахь хөрөнгийг татан авч байршуулах асуудлыг хэлэлцэх ажлын хэсэг аймгийн Засаг даргын 2025 оны А/138 дугаар захирамжаар байгуулагдаж асуудлыг хэлэлцэн ХААН, Капитрон банкуудаас санал авч ХААН банктai хамтран ажиллах гэрээнд аймгийн ЗДТГ-аас Тусгай зориулалтын санд 300.0, банкаас 300.0, нийт 600.0 сая төгрөг, Капитрон банктai хамтран ажиллах гэрээнд аймгийн ЗДТГ-аас Тусгай зориулалтын санд 310.0, банкаас 310.0, нийт 620.0 сая төгрөг байхаар тусгаж нэмэлт өөрчлөлт оруулан гэрээ байгуулсан. Аймгийн ЖДҮ эрхлэгчдийг дэмжих сангаас зээл хүссэн хүсэлтүүдийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж 5 төслийг дэмжин банкинд уламжилсан. Одоогоор явган замын хавтан үйлдвэрлэх тоног төхөөрөмж худалдан авах чиглэлийн төсөлд 58.9 сая төгрөгийн зээл олгогдож бусад төсөл судлагдаж байна.	2025-01-01 2025-06-05	90
13.	1.13.Согтууруулах ундаа худалдах, үйлчилгээ эрхлэх хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг хүлээн авч ажлын хэсэгт танилцуулах, холбогдох шийдвэрийг аж ахуйн нэгжүүдэд хүргэх	-Хүлээн авсан хүсэлтийн тоо	Хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлтийг мэдээлсэн.	Хүсэлтийг шийдвэрлэн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид 2023 оны 11 дүгээр сарын байдлаар согтууруулах ундаа худалдах 320, үйлчлэх 112, нийт 432 цэг байсан. Тайлант хугацаанд согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэг 109, худалдах цэг 350, нийт 414 цэг байна. Зургаан сараас дээш хугацаагаар тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулаагүй 5 цэгийн тусгай зөвшөөрлийг цуцалсан. Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр ханган ажиллаж байна.	2025-01-01 2025-06-05	100

					ХХААХҮ-ийн сайдын 2023 оны А/419 дүгээр тушаалаар согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд тавигдах шаардлага батлагдсантай холбогдуулан холбогдох хууль, тогтоомж, тушаал, бүрдүүлэх материалын талаар аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл тогтмол хүргэж байна. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг https://e-business.mn/ системээр хүлээж авч, ажлын хэсгийн хурлыг 3 удаа хийж, тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгжүүдээр улсын тэмдэгтийн хураамж төлүүлэн, тусгай зөвшөөрлийг цахимаар хүргэж байна. Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамжийн орлогын мэдээг гаргаж CTCX-т хүргүүлэв. 2022 онд 55.3, 2023 онд 49.7, 2024 онд 404.5 сая төг, 2025 оны хагас жилийн байдлаар 36.5 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрсөн байна.		
14.	1.14.Худалдаа, үйлчилгээ эрхлэгчидтэй холбогдох чиглэлээр хамтран ажиллах	-Хамтран хэрэгжүүлсэн ажлын тоо	Холбогдох чиглэлээр хамтран ажилласан.	Холбогдох чиглэлээр хамтран ажилласан байна.	Ил задгай худалдаа эрхлэх хүсэлтэй иргэд, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжүүдэд холбогдох мэдээлэл өгч, хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна.	2025-01-01 2025-06-05	100
15.	1.15.Салбарын чиглэлээр иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, хариу мэдэгдэх	Өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлтийн хувь	41 өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэсэн.	Өргөдөл, санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.	Тайлант хугацаанд худалдаа үйлчилгээ, хөнгөлөлттэй зээл, согтууруулах ундааны үйлчилгээний газартай холбоотой гаргасан, Цагдаагийн газраас ирүүлсэн зэрэг 20 өргөдөл, гомдол, санал хүсэлт хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэж хариу хүргүүлсэн. Удирдлагаас ирүүлсэн 1, хурлын 25 үүрэг даалгавар биелүүлж 5 бичиг шийдвэрлэн, 2 өргөдөл гомдлыг шийдвэрлэн хариу мэдэгдсэн байна. Тайлант хугацаанд салбарын чиглэлээр 123 бичиг хүлээн авч, 61 албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. 26 захирамж төлөвлөн гаргасан.	2025-01-01 2025-06-05	100
Зорилт 2. "Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах"-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт							
1.	2.1.Салбарын хууль, бусад хууль, тогтоомж, шийдвэрийг үндэслэн захирамж, шийдвэрийн төсөл боловсруулах	-Захирамж, шийдвэрийн тоо	Захирамжийн 55 төсөл боловсруулан ажилласан.	Захирамжийн биелэлтийг ханган ажилласан байна.	Тайлант хугацаанд 26 захирамж боловсруулан ажилласан.	2025-01-01 2025-06-05	100


2.	2.2.Салбарын чиглэлээр удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангах, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах	-Өгөгдсөн үүрэг даалгаврын тоо, биелэлт	Салбарын чиглэлээр 77 үүрэг даалгаврын биелэлтийг хангасан.	Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг 100 хувь биелүүлэн ажилласан байна.	Тайлант хугацаанд салбарт холбогдох чиглэлээр удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан.	2025-01-01 2025-06-05	90
Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт							
1.	3.1.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, шаардлагатай мэдээллийг хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх;	Тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлэх	Биелэлт, холбогдох албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн.	Биелэлт, албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох газарт хүргүүлсэн байна.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг сар бүр, бусад тайланг тайлант хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэхээр ажиллаж байна.	2025-01-01 2025-06-05	100
2.	3.2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	Хууль тогтоомжийг биелүүлэн ажиллана.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллана.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	2025-01-01 2025-06-05	100

Мэдлэг, үр чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1.							

1.	Хууль, эрх зүйн мэдлэгийг бие даан сайжруулах	Хууль, эрх зүйн мэдлэгийг бие даан сайжруулсан байна.	Холбогдох хууль тогтоомжийг судласан.	Холбогдох хууль тогтоомжийг судлан мэдлэгээ сайжруулна.	Согтууруулах ундаа худалдах, үйлчлэхтэй холбоотой батлагдан гарсан хууль тогтоомж болон салбарын чиглэлийн, төрийн албаны, бусад холбогдох хууль тогтоомж шийдвэрийг судалж ажиллаж байна.	2025-01-01 2025-06-05	100
2.	Холбогдох зөвлөгөөн, сургалтад хамрагдах хурал,	-Хамрагдсан сургалтын тоо	Холбогдох мэдээлэл авсан.	Холбогдох хурал, зөвлөгөөн, сургалтад хамрагдаж мэдээлэл авна.	Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий УИХ-ын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг манай аймагт ажиллаж, хэлэлцүүлэгт жижиг, дунд үйлдвэрлэл болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 180 иргэн, аж ахуйн нэгжүүд оролцож санал өгсөн. Малчид тариаланчдын зөвлөгөөн 2025-04-25нд Жаргалант суманд зохион байгуулагдаж 200 хүнийг хамруулсан. Монгол улсын их хурал, Засгийн газар, орон нутгийн бодлого, шийдвэрүүдийг танилцуулж санал хүсэлт авч ажилласан. 2025-04-27нд Хоршоологчдын хойд бүсийн зөвлөгөөн Булган аймагт зохион байгуулагдаж аймгийн хоршоодын 20 төлөөлөл оролцсон. Хойд бүсийн түншлэл-2025 эдийн засгийн форумын зохион байгуулалтад оролцсон. Байгууллагаас зохион байгуулсан сургалт, зөвлөгөөнд оролцож байна.	2025-01-01 2025-06-05	100
3.	Үндэсний бичгийн сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байх	Сургалтад хамрагдсан.	Сургалтанд хамрагдсан байна.	Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан үндэсний бичгийн анхан, дунд шатны сургалтад хамрагдсан.	2025-01-01 2025-06-05	90

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХОРШОО, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ,
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГО ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



Б.БААСАНСҮРЭН